



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар

Жавхлант

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нийгмийн даатгалын байцаагч

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

Цахилгаан түгээх станцын шуурхай үйлчилгээний засварын монтер

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажлыг удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр сумын Засаг даргад танилцуулж ажиллахыг Зөвлөлийн дарга (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/63 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.БАТЧУЛУУН

D:Zasag darga /zahiramj-2025/